



“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ХК

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ:

Тайлбар: Нийслэлийн 2022 оны төсөвт 2474,1 сая төгрөг тусгагдаж гүйцэтгэгчээр “Энх өглөө” ХХК нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулан тус ажлыг гүйцэтгэсэн. Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний А/206 дугаар тушаалын дагуу Улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр ажиллаж шугамыг ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х17мВА чадалтай үндсэн дэд станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд: Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х17мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн.

Гүйцэтгэгчээр “Эм Ай Эс Эс” ХХК нь шалгарч 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай №ОН2512001438 гэрээ байгуулсан. Дэд станцын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажил эхлэх зөвшөөрлийг холбогдох байгууллагад хүргүүлсэн хүлээгдэж байна.

Мэдээлэл өгөх ажилтан:

Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн

газрын дарга Б.Мөнгөнхуяг. Утас: 88656964